

МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11-р сарын 10-ны өдөр

№ 21/11

Улаанбаатар хот

2022 оны санхүүгийн тайланд аудит хийх
хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10, 76.1.18 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.3 дахь заалт, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.16.2, 10-р зүйлийн 10.1, 10.2, 12-р зүйлийн 12.8 дахь заалт болон 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос гаргасан саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагаар “БДО Аудит” ХХК-ийг сонгон, гэрээний нөхцөлийг тодорхойлж, ажлын хөлс хэмжээг тохиролцон, гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавин хамтран ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо /О.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.
2. Аудитын байгууллагатай гэрээ хэлцэл хийх, компанийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах, аудитын ажилтныг ажиллах нөхцөлөөр хангах, аудитын байгууллагаас гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГ  Х.АНАНД